



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Asian Development Bank

Japan
Fund for
Poverty
Reduction

ШҮҮСТ ТЭЖЭЭЛ



Шүүст тэжээлийн гол онцлог нь түүний найрлаганд байгаа ус нь бусад бодистой нэгдэж эсийн бүрэлдэхүүнд орсон байдагт оршино. Шүүст тэжээлд хадлан бэлчээрийн нялх ногоон ургамлаас гадна дарш, өвсөн дарш, үр тарианы өвсөн дарш болон үндэс ба булцуу үртэн (чихрийн ба тэжээлийн манжин, шар манжин, лууван, төмс) хамаарагдана.

Дарш, өвсөн дарш: Нүүрс усаар баялаг ногоон ургамлыг хэрчиж жижиглэн тусгай төхөөрөмжинд нягтруулан агааргүй орчинд сүүн хүчлийн исэлдэлгээ явуулах замаар нөөцөлж хадгалсан тэжээлийг дарш гэнэ. Ургамлын чийгийн хэмжээнээс хамаарч 2 төрлийн дарш бэлтгэнэ.



Дарш бэлтгэхэд нэг наст тарималуудыг өргөн ашигладаг. Түүхий эдийг 60-75 хувийн чийгтэй үед нь даршлахад тохиромжтой. Сайн даршлагддаг ларшийг 72 хувиас доош чийгтэй, муу даршлагддаг бол 45-55 хувийн чийгтэй даршилахад

Дарш хийхдээ нүх буюу тусгай бэлтгэсэн савыг 1-2 өдрөөс хэтрүүлэлгүй аль болох богино хугацаанд дүүргэж таглах хэрэгтэй.

Дарш хийснээс хойш 40-45 хоногийн дараа малд өгөхөд бэлэн болно. Даршийг задалж хэрэглэхдээ өдөр өдөрт хэрэглэх хэмжээгээрээ

Дарш нь ямар ч малд өгч болох сайн тэжээл саалийн малд илүү тохиромжтой.

Монгол үнээнд өвсөн даршаар 5-10 кг, саалийн 20 кг, хонинд 1-1.5 кг, тугалд 3-4 сартайгаас нь 500 граммаар өдөрт өгнө.



авна.
боловч

үнээнд 15-
эхлэн 200-



Өвсөн дарш: Хялбаршуулах нүүрсусаар баялаг ногоон ургамлыг хадаж 45-55%-ийн чийгтэй болтол сэврээж, хэрчиж жижиглээд зулж нягтруулан битүү хадгалсныг өвсөн дарш гэнэ.

Овёос арвай, хөх тариа 50-60%

Халгай, лууль, шарилж, байгалийн бэлчээр, хадлангийн ямарч ургамлаар бэлтгэх боломжтой.

Өвсөн дарш нь шингэц, шимт чанараараа сайн бөгөөд бүдүүн тэжээл, шүүст тэжээлийг нэгэн зэрэг төлөөлж чаддагаараа

онцлогтой.

Давуу тал: Ургамлын навч, цэцэг бүрэн хадгалагддаг учир витамин болон шимт бодисоор ердийн хадаж бэлтгэсэн өвснөөс баялаг.

Даршлах дараалал:

✓ Ургамлыг хадах, хэрчих

- ✓ Хэрчсэн ургамлыг даршлах саванд хүргэх
- ✓ Хэрчсэн ургамлыг зулж нягтруулах
- ✓ Хучиж битүүмжлэх

Өвсөн даршийг бүдүүн үнээнд 20-25кг, гунжин үнээнд 10-15кг, бяруунд 6-10кг, хурга, ишгэнд 0.5-1 килограммыг өглөө, оройд хувааж өгнө.

Үндэс ба булцуу үртэн: Шүүст тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх, хялбар шингэх нүүрсус болон зарим витаминаар хангахад үндэс ба булцуу үрт ургамал нэн чухал ач холбогдолтой.

- **Төмс:** Малын тэжээлд өргөн хэрэглэгддэг ногооны нэг нь төмс юм. 25 хувийн хуурай бодис агуулах ба үүний 1-2 нь уураг, бусад хэсэг нь үндсэндээ цардуул байдаг. Төмс 0.25-0.28тн/кг ерөнхий шимт чанартай. Үхэр, хонь, ямаа адуунд хэрчиж жижиглэн түүхийгээр, гахайнд заавал чанах буюу уураар чанаж өгнө. Хээл хүндэрч төллөх хугацаа нь ойртсон малд өгөх хэрэггүй. Болгосон төмс амархан гэмтэж муудах тул тухайн өдөрт нь багтааж хэрэглэх хэрэгтэй.
- **Тэжээлийн манжин:** 10-12 хувийн хуурай бодистой ба ерөнхий шимт чанар нь 0.13 тн/кг. Тэжээлийн манжин нь бүх төрлийн малд тохиромжтой сайн тэжээл болох тул үхэр, хонь, ямаа, адуунд түүхийгээр нь хэрчих буюу хэрчихгүйгээр өгнө. Тэжээлийн манжинг чанах буюу уураар жигнэж 12 цагаас илүү хугацаанд хадгалбал азотлог бодисын задралаас нитрит үүсч малыг хордуулах магадлал өндөр. Иймээс хөргөсний дараа богино хугацаанд тэжээлд ашиглах хэрэгтэй.
- **Чихрийн манжин:** Чихрийн манжинг сүүлийн үед малын тэжээлд өргөн ашиглаж байна. Манжинг түүхийгээр хэрчиж саалийн үнээнд 6-8 кг хүртэл хэмжээгээр өгч болно. Манжингаар тэжээсэн үнээний саам нэмэгдэх боловч их хэмжээгээр шээх учраас хэвтрийг нь байнга хуурайлж байвал зохино.
- **Тэжээлийн лууван:** Энэ ургамал 8-13 хувийн хуурай бодистой. 0.12-0.18 тн/кг, 20-250 мг/кг каротинтой байдаг. Луувангаар тэжээсэн үнээний сүү каротин, А витамин ихтэй тул цөцгий болон тос нь шаргал өнгөтэй, амт чанар сайтай болно. Лууванг хураасны дараа түүний ногоон ишийг нимгэн үеэр сараалжин дэлгэц дээр тавьж хатаан тэжээлд ашиглах боломжтой.
- **Байцаа:** Байцааг малд шинэхэн байдлаар нь ашиглахаас гадна даршилж ашиглана. Тэжээлийн байцаа хүйтэнд тэсвэртэй учир 6-8 хэмийн хүйтэнд ч талбайд байлгаж болдог. Байцаагаар саалийн үнээ тэжээхэд нэн тохиромжтой. Саалийн үнээнд хоногт дунджаар 20-25 кг-ийг өгч болох боловч дарштай 1:1-ийн харьцаагаар хольж өгнө.

Шүүст тэжээлийг бэлтгэж мал тэжээх норм, кг

Тэжээлийн нэр	Малд хоногт өгөх тэжээлийн хэмжээ, кг			
	Саалийн үнээнд	Хонь,ямаанд	Адуу	Гахай
Төмс	10-25	2.0	10-15	8-10
Тэжээлийн манжин	30-35	4-5	10-15	5-7
Чихрийн манжин	6-8	-	-	2-3
Байцаа	20-25	-	-	10-15

Боловсруулсан: МААЭШХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан Л.Алтанцэцэг